



УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ИХ ЭМЧ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Уламжлалт анагаах ухааны идээ ундаа, явдал мөрийн урьдчилан сэргийлэх аргын тухай нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;
2. Уламжлалт анагаахын эмнэлзүйн тохиолдолд суурилсан уламжлалт амирлуулах /тан, талх, үрэл, ханд, архин, тосон, зуурмал, үнсэн/ эмийн сонголт, хослон хэрэглэсэн туршлага, үр дүнгийн тайлан /холбогдох материалыг хавсаргах/;
3. Зонхилон тохиолдох өвчний үеийн хануур заслаас өргөн хэрэглэдэг 10 -аас доошгүй судсыг ханадаг байх /тайлан, бичлэг, CD ирүүлэх/;
4. Сургалт эрхлэх байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдан багц цагийн бүрдүүлэлтийн 50%-ийг бүрдүүлсэн байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Уламжлалт анагаах ухааны идээ ундаа, явдал мөрийн урьдчилан сэргийлэх аргын тухай нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг бүс нутагт зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;
2. Уламжлалт анагаах ухааны эмнэлзүйн тохиолдлын үеийн уламжлалт амирлуулах, арилгах эмийн эмчилгээг хийдэг байх /холбогдох материалыг хавсаргах/;
3. Уламжлалт анагаах ухааны ширүүн заслуудаас хануур, хатгуур зэрэг өндөр ур чадвар шаардах заслуудыг хийдэг байх /тайлан, CD ирүүлэх/;
4. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож, бүтээл хэлэлцүүлж, анагаах ухааны мэргэжлийн хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл, хэвлэлд нийтлүүлсэн байх;
5. Сургалт эрхлэх байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/зохион байгуулсан багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдан багц цагийн бүрдүүлэлтийн 50%-ийг бүрдүүлсэн байх.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Уламжлалт анагаах ухааны мэргэжлийн чиглэлээр эмнэлзүйн сургагч багш болсон байх;
2. Уламжлалт анагаах ухааны идээ ундаа, явдал мөрийн урьдчилан сэргийлэх аргын тухай нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;
3. Уламжлалт анагаах ухааны 4 ерөндгөөр амжилттай эмчилсэн үр дүн, тайлан;
4. Зонхилон тохиолдох өвчин, түүний хүндрэл, ховор тохиолдох эмгэгийн үеийн Уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээний чиглэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх шатлалын эмнэлэгт зөвлөгөө өгөх мэдлэг чадвартай байх;
5. Сургалт эрхлэх байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдан багц цагийн бүрдүүлэлтийн 50%-ийг бүрдүүлсэн байх.